# Алсын хараа - 2050

## Барилга, хот байгуулалтын яам

## 2022 оны хагас жил

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ | | | | | | | |
| 1 | 1.1. Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна. | 1.1.10. Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэнэ. | 2020 - 2050 | - | Мэдээллийн кадастрын санд бүртгэх ажлыг эхлүүлнэ. | Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгүүлэх хүсэлт холбогдох газруудаас ирээгүй байна. | 0% |
| Хоёр. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | |
| 2 | 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, | 2.2.32. Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцөлийг орон сууцны гадна талбай, сургуулийн орчинд | 2020 - 2050 | | Зураг төсөл боловсруулна. | -Сургуулийн спорт заал /540 м2/, Сургуулийн спорт заал 720м2 зураг төсөл гүйцэтгэх ажлыг 2021 онд дуусган БШУЯ-нд хүлээлгэн өгсөн. -Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар баригдах “President” спорт цогцолборын барилгыг Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт төлөвлөж байгаа бөгөөд шаардлагатай зургийн даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд “Говь трэйвэл” ХХК-тай гэрээ байгуулж эскиз зургийг зөвшилцөж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. | бүрдүүлнэ. | | | | | |
| 3 | 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана. | 2.5.1. Орон сууцны нэг хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ. | 2020 - 2050 | - | БНбДүрэм боловсруулна. | Барилга, хот байгуулалтын яамны Барилга байгууламжийн норм, номативын сангийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт" /БНбД 31-01-10/-ыг шинэчлэн боловсруулахаар тусгагдсан. Судалгааны ажил хийгдэж, норм дүрмийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. | 30% |
| 4 | | 2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020 - 2050 | Нийслэлийн төсөв - 560,0 сая төгрөг | "Паспортжуулсан барилга байгууламжийн тоо - 180 | Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 127 дугаар тушаалаар баталсан. 2020 оны байдлаар Улсын хэмжээнд 2002 оноос өмнө баригдсан 7672 барилга байгууламж ашиглагдаж байгаагаас нийслэлд 1844, аймаг орон нутагт 5828 барилга байгууламж байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд 780 барилга байгууламжийг паспортжуулсан бөгөөд үүнээс 188 барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй, 131 барилга байгууламж нь хүчитгэх шаардлагатай, 461 барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэргүй гэсэн дүгнэлт гарсан. Цаашид Нийслэлийн 988 олон нийтийн барилга байгууламжийг паспортжуулахад 6,9 тэрбум төгрөг, аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн 2142 барилга байгууламжийг паспортжуулахад 14,9 тэрбум төгрөг тус тус шаардлагатай байгаа талаарх танилцуулгыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. 2022 оны Нийслэлийн төсөвт 560 сая төгрөгөөр 172 барилга байгууламжийг паспортжуулах ажил туссан бөгөөд үүний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар зохион байгуулан ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалаар Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын санхүүжүүлэх боломжтой 10 төрлийн зардалд паспортжуулах ажлын зардлыг тусган санхүүжүүлэх боломжийг оруулж баталж, үүрэгжүүлэн, хяналт тавин ажиллаж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамнаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгах барилгын | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салбарт хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний саналыг 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1651 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлээд байна. | |
| 5 | | 2.5.3. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2020 - 2050 | хувийн хөрөнгө оруулалт - 516,0 тэрбум төгрөг | Үе шаттай хэрэгжүүлнэ. | Улсын хэмжээнд 2021 онд 504, 2022 оны хагас жилийн байдлаар нийт 528 амины орон сууц, нийт 1032 орон сууц ашиглалтад орсон байна. Үүнээс: Улаанбаатар хотод 134, орон нутагт 394 амины орон сууц ашиглалтад орж улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна. Цаашид Сангийн яам, Монголбанк болон арилжааны банкуудтай хамтран инженерийн дэд бүтцэд холбогдсон амины орон сууц барьсан иргэдэд хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор ипотекийн зээл олгохоор төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна. Амины орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан орон сууцанд хамаарах техник хяналтын журам боловсруулж, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын захирлын тушаалаар 2021 оны 06 дугаар сард батлуулсан. Мөн санхүүжилтийн журмыг батлаж, зээлийн санхүүжилтийг эхлүүлэхээр Монголбанк, Арилжааны банкуудтай хамтран ажиллаж байна. Мөн Нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар хэрэгжүүлж буй "Дэд бүтцийн төв" төслийн хэрэгжилтийг дэмжиж, иргэдийн амины орон сууцны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. | 50% |
| 6 | | 2.5.5. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ. | 2020 - 2050 | - | Боловсруулсан хөжлийн ерөнхий төлөвлөгөө, тоо 8 | Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлыг Нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ хариуцан гүйцэтгэж байна. Тус ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хотын суурьшлын хилийг дагуулан 50м өргөнтэй суурьшлыг хязгаарлах ногоон бүс байгуулах, байгалийн унаган төрхөөрөө байгаа газруудад болон төлөвлөлт хийж байгаа дэд төвүүдэд цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулах, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 2040 онд 35-40 хүн/м2 хүргэх зэрэг төлөвлөлтийн шийдлүүдийг тусган боловсруулж байна. Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 99 дүгээр тогтоолоор баталсан. Хотын суурьшлын бүс, орон сууцны хороолол, Хараа голын татмын хэсгийн ногоон байгууламж, явган болон дугуйн зам дагасан ногоон гудамж, “Хотын төв цэцэрлэгт хүрээлэн –Дархан 50” цэцэрлэгт хүрээлэн зэрэг ногоон бүсийн нэгдсэн сүлжээг бий болгохоор ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 29 дугаар тогтоолоор баталсан. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шинэ Зуунмод хотыг ногоон хот (Green city)-ын зарчмаар төлөвлөсөн бөгөөд тус хотод ногоон байгууламж, эко төлөвлөлтийг бий болгохыг зорьсон. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж-281.1 га, тусгай зориулалтын ногоон байгууламж - 342.4 га, цэцэрлэгт хүрээлэн - 1475.8 га ногоон байгууламж байхаар төлөвлөсөн. | |
| 7 | | 2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020 - 2050 | | Дүрэм, журам стандарт -4 -ийг батлуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: 1.Айл өрх, нийтийн үйлчилгээний газруудын угаалга, ариун цэврийн өрөө, зүлэг, ногоон байгууламжийн усалгаа зэрэг ундны бус ахуйн хэрэглээний зориулалтаар ашиглах "Борооны ус хуримтлуулах систем. Хэрэглээний дүрэм: MNS BS 8515:2019" стандартыг 2019 онд боловсруулж, батлуулсан. Энэхүү стандартыг борооны ус цуглуулж ундны бус зориулалтаар ашиглах ус хангамжийн системийн зураг төсөл боловсруулах, угсрах, шалгах, засвар үйлчилгээ хийхэд ашиглаж болно. 2."MNS BS 8525 - 1 : 2015 Саарал усны систем. Ерөнхий шаардлага." стандартыг ундны бус усны хэрэглээг хангах, угаалгын өрөөний саарал усыг дахин ашиглах системийг зохион бүтээх, суурилуулах, өөрчлөлт хийх, турших, засвар үйлчилгээ хийхэд ашиглана. 3.Цэвэрлэсэн усыг дахин ашиглах гарын авлага. MNS-ISO-16075-1 : 2018 цуврал стандартыг газар тариалан, нийтийн цэцэрлэгт хүрээлэн, гаднах талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ашиглана. 4."Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6734:2018" стандартыг нүүрс угаах, бетон бэлтгэх, дулааны станц, хог хаягдал боловсруулах үйлдвэр, машин угаалга, суултуур зайлах, ариутгах татуургын засвар, үйлчилгээ, туршилт, түймэр унтраахад ашиглах боломж бүрдсэн. | 100% |
| 8 | | 2.5.7. Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулна. | 2020 - 2050 | | Сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн 16 суманд цэвэрлэх байгууламжийг шинээр барих, шинэчлэх төсөл хэрэгжиж байна. БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байна. Мөн БНПольш Улсын нөхцөлт зээлийн хөрөнгөөр баруун 5 аймгийн бохир усны цэвэрлэх байгууламжийг шинэчилнэ. Эдгээр төслүүдийн хүрээнд иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулж байна. | 90% |
| 9 | | 2.5.10. Хог хаягдлын | 2020 - | АХБ -5,8 | Төслийн | Ядуурлыг бууруулах Япон сангийн 2.0 сая ам долларын буцалтгүй тусламжийн | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ. | 2050 | тэрбум төгрөг | хэрэгжилт 100% | "Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн G9206 төсөл”-ийг Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Говь-Алтай, Сүхбаатар аймгийн төвд хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг шинээр барьж байнгын ашиглалтад оруулсан. Дархан-Уул аймагт дахивар хүлээн авах барилгын угсралтын ажил 85%-тай, Хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах барилгын угсралтын ажил Говь-Алтай аймагт 20%-тай, Сүхбаатар аймагт 50%-тай, Өвөрхангай аймагт автопүү, дахивар хүлээн авах барилгын угсралтын ажил 85%-тай. Төслийн хэрэгжилт 77%-тай. | |
| 10 | | 2.5.11. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор өргөтгөж, шинэчилнэ. | 2020 - 2050 | АХБ - 25,7 тэрбум төгрөг БНПольш Улсын зээл - 3,8 сая евро | Төслийн хэрэгжилт 100% | Улаанбаатар, аймгийн төв, суурин газруудын бохир ус цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологиор шинэчилж, шинээр барьж байна. Үүнд: 1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн барилгын ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна. 2. АХБ-ны зээлээр нийт 10 аймгийн 12 суманд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барьж байна. Үүнээс Архангай, Өвөрхангай, Булган, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл зэрэг 6 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100%. туршилт, тохируулга 66- 80%-тай байна. Дорноговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажил 95%, Дундговь аймгийн төв 95%, Сүхбаатар аймгийн төв 68%, Дархан-Уул аймгийн төв 80%, Өвөрхангай аймгийн Хужирт сум 90%, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 85%-тай байна. 2022 онд 25,784.64 сая төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. 3. БНПУ-ын Засгийн газрын зээлээр Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулсан. Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил 70%, Дорнод аймгийн төв 20%-ийн гүйцэтгэлтэй байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3,809,142 еврогийн урьдчилгаа олгосон.<br>4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн төв, Улаанбаатар хотын Багануур дүүргийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулах ажлын зөвлөхийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Зураг төслийн боловсруулалт Говь-Алтай Говь-Алтай аймаг 10%, Улаанбаатар хот Багануур дүүрэг 30%-тай, 5. Баянхонгор аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар батлагдах | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатандаа байна. | |
| 11 | | 2.5.12. Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | Орон нутгийн төсөв - 3,0 тэрбум төгрөг | Үе шаттай хэрэгжүүлнэ. | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Нийспэлд хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл нь 10 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад дэд төвүүдийг байгуулна. Төслийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Нийслэлийн төсвөөс бүрдүүлж байна. Төслийн хүрээнд инженерийн дэд бүтэц, нийгмийн барилга байгууламж барих 79 ажил төлөвлөсөн бөгөөд 2016-2021 онд 34 ажил хэрэгжиж дууссан бол 13 ажил нь 2022 үргэлжлэн хэрэгжихээр байна.Энэ 13 ажлаас гэр хорооллын инженерийн шугам сүлжээтэй холбоотой 10 ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 30-90%-тай байна. СБД-ийн 18-р хороонд 200 айлыг цахилгаан, цэвэр, бохир ус болон дулаан хангамжид холбох 1-р ээлжийн “Бичил дэд төв”-ийн ажлын гүйцэтгэл 95%-тай хэрэгжиж байна. | 50% |
| Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА | | | | | | | |
| 12 | 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн орон байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3.2.1. Нийслэл, түүний дагуул, хаяа хот, тосгон, орон нутагт, хүн амын орлогод нийцсэн, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг бодлогоор дэмжинэ. | 2020 - 2050 | 99,9 тэрбум төгрөг - Монгол банк | 42000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. | Хүн, ам орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр улсын хэмжээнд 32,800 өрх түрээсийн орон сууцанд амьдарч байгаагаас 3,994 нь төрийн өмчийн түрээсийн орон сууцанд амьдарч байна. Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хүрээнд 2020 онд “НОСК НЭГ ТЗК” ХХК-иар дамжуулан 34.5 тэрбум төгрөг түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 420 орон сууцыг худалдан авч 420 албан хаагчийг орон сууцаар хангаад байна. “НОСК ХОЁР ТЗК” ХХК-иар дамжуулан 39.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 447 айлын орон сууцыг худалдан авч 447 албан хаагч, “НОСК ГУРАВ ТЗК” ХХК-иар дамжуулан 26 тэрбум төгрөгөөр 310 айлын орон сууцыг худалдан авч 310 албан хаагч, 50.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 757 албан хаагчийг орон сууцжуулаад байна. Нийт 2020 -2021 онд нийт 1177 төрийн албан хаагчийг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 99.9 тэрбум ₮-ийн үнийн дүн бүхий түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцанд хамруулаад байна. Үүнээс 1025 нь нийслэлд 152 нь орон нутагт байна. Төрийн өмчийн түрээсийн орон сууцны тоо 2022 оны хагас жилийн байдлаар 5584 болж өссөн байна. Цаашид төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх хүрээнд 2021 оны байдлаар улс, нийслэлийн төсөв, олон улсын хөгжлийн санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэлээр орон сууцны хороолол барих 8 төслийг хэрэгжүүлж байна. Уг төслүүд хэрэгжснээр нийт 217.27 га талбайд 2027 он хүртэлх хугацаанд нийт 28,185 айлын орон сууц ашиглалтад орно. | |
| 13 | | 3.2.2. Худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны зураг төслийг боловсруулж, норм, стандарт, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 2020 - 2050 | Улсын төсөв - 500 сая төгрөг | Залуус хорооллын иж бүрэн зураг төслийг боловсруулж батлуулна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 43 дугаар захирамжаар “Залуус” орон сууцны цогцолбор хороолол байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус яамнаас төслийн концепц, техникийн шийдлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын 57 га талбайд төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. "Залуус" орон сууцны цогцолбор хороолол барих ажлын даалгаврыг Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч хамтран 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 2021/03 дугаартай баталсан. Батлагдсан ажлын даалгаврын дагуу “Залуус 1” орон сууцны хорооллын техник эдийн засгийн урьдчилсан судалгаа, эх загвар зураг /эскиз/ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсан. Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгсөн. Архитектур төлөвлөлтийн даалгавар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Эх загвар зураг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тус тус батлагдсан. Хорооллын цахилгаан хангамж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, авто зам, замын байгууламжийн доогуурх хонгилын систем, гадна инженерийн шугам сүлжээ, дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ болон орон сууцны барилгын ажлын зураг төслүүдийг олгогдсон техникийн нөхцөлийн дагуу бүрэн боловсруулж дууссан. | 90% |
| 14 | | 3.2.3. Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах | 2020 - 2050 | Монгол банк - 249,5 тэрбум төгрөг | 23000 өрхийг ипотекийн зээлд | Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрт давхардсан тоогоор нийт 100 орчим мянган | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, аятухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ. | | | хамруулна. | өрх хамрагдсан бөгөөд нийт 6 орчим их наяд төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөрт зориулан гаргасан байна. Орон сууцны нийлүүлэлтийг дэмжих, иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний дагуу ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт 2021-2024 оны хооронд нийт 2 их наяд төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. 2022 оны хагас жилийн байдлаар 249.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 2886 зээлдэгчид олгосон. Үүнээс 218 тэрбум ₮-ийн 2279 зээлийг Улаанбаатар хотод, 52.8 тэрбум ₮-ийн 838 зээлийг орон нутагт олгоод байна. Мөн 2020 онд 5594 өрх, 2021 онд 13292 өрх, 2022 оны хагас жилийн байдлаар 3117 өрх нийт 22003 өрх ипотекийн зээлд хамрагдаад байна. | |
| 15 | | 3.2.4. Төр, орон нутаг, хэвийн хэвшлийн оролцоотой 60,000 айлын “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 99,9 тэрбум төгрөг - Монгол банк | 34000 | Хүн, ам орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр улсын хэмжээнд 32,800 өрх түрээсийн орон сууцанд амьдарч байгаа бөгөөд үүнээс 3,994 нь төрийн өмчийн түрээсийн орон сууцанд амьдарч байсан. Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын хүрээнд 2020 онд “НОСК НЭГ ТЗК” ХХК-иар дамжуулан 34.5 тэрбум төгрөг түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 420 орон сууцыг худалдан авч 420 албан хаагчийг орон сууцжуулаад байна. 2021 онд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн охин компани болох “НОСК ХОЁР ТЗК” ХХК-аар дамжуулан 39.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 447 айлын орон сууцыг худалдан авч 447 албан хаагч, “НОСК ГУРАВ ТЗК” ХХК-иар дамжуулан 26 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 310 айлын орон сууцыг худалдан авч 310 албан хаагч, 50.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 757 албан хаагчийг орон сууцжуулаад байна. Нийт 2020-2021 онд нийт 1177 төрийн албан хаагчийг 99.9 тэрбум ₮-ийн үнийн дүн бүхий түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцанд хамруулаад байна. Үүнээс 1025 нь нийслэлд 152 нь орон нутагт байна. 2022 оны хагас жилийн байдлаар төрийн өмчийн түрээсийн орон сууцанд нийт | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 33917 өрхийг хамруулаад байна. | |
| 16 | | 3.2.5. Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | 2020 - 2050 | хувийн хэвшил | Нийт 15000 айлын орон сууц ашиглалтад орсон байна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07/19 тоот, 12/43, 2014 оны 19/23 тоот, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 161 дүгээр тогтоол, 2020 оны 48 дугаар тогтоол, 2021 оны 122 дугаар тогтоолуудаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийтдээ 28 байршилд 85 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 18 байршлын 56 хэсэгчилсэн талбайд 43 төсөл хэрэгжиж байна. 2022 онд эхний хагас жилийн байдлаар 959 айлын орон сууц ашиглалтад орсон бөгөөд оны сүүлийн хагаст 6033 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Нийт 2013 оноос хойш өссөн дүнгээр 11755 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байна. Дээрх 43 төсөл хэрэгжүүлэгчийн ажлын явц өнөөдрийн байдлаар: хэвийн үргэлжилж байгаа 18 төсөл , хэрэгжилт удаашралтай 17 төсөл, хэрэгжиж дууссан 1 төсөл байна. | 70% |
| 17 | | 3.2.6. Орон сууцны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тухайн орон сууцны тодорхой хувийг бага, дунд орлоготой иргэдэд түрээслүүлэх, хямд үнээр борлуулах замаар орлогод нийцсэн орон сууцаар хангана. | 2020 - 2050 | хувинй хэвшил | Нийт 8300 айлын орон сууц ашиглалтад орсон байна. | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийт 27 байршил, 50 хэсэгчилсэн талбайд 33 төсөл хэрэгжүүлж байна. 2022 оны хагас жилийн байдлаар төслүүдийн хүрээнд 11755 орон сууц ашиглалтад орсон байна. Иргэдийн орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд 2021 оны байдлаар улс, орон нутгийн төсөв, олон улсын хөгжлийн санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэлээр орон сууцны хороолол барих 8 төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүд хэрэгжсэнээр 217.27 га талбайд 2027 оны түвшинд нийт 28,185 айлын орон сууцны цогцолбор хороолол баригдаж, 100,000 орчим иргэн тав тухтай инженерийн дэд бүтцэд холбогдсон, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. 2022 оны хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 5584 төрийн өмчийн түрээсийн орон сууцны сан бий болсон байна. | 50% |
| 18 | | 3.2.7. Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн | 2020 - 2050 | - | Хэрэгжилтийг хангана. | БХБСайдын 2017 оны өдрийн 26 дугаар тушаалаар баталсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2022 оны хагас жилийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн нийт 5584 түрээсийн орон сууцанд иргэдийг хамруулсан. Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 138 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ. | | | | сууцыг өмчлүүлэх"журмын хүрээнд иргэд амьдарч буй түрээсийн орон сууцныхаа урьдчилгаа 30 хувийг 5 жилд багтаан бүрдүүлж, үлдсэн төлбөрийг ипотекийн зээлд хамрагдах хэлбэрээр төлөх эсхүл нийт төлбөрийг ямар нэгэн хүү болон ашгийн нэмэгдэлгүйгээр 5 жилд тэнцүү хуваан төлж, өөрийн өмчид шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Цаашид уг журмын хэрэгжилтийг дүгнэж, холбогдох сайжруулалт, нэмэлт өөрчлөлтийг олон улсын сайн туршлагад тулгуурлан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн төрөөс төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх хүрээнд 2021 оны байдлаар улс, орон нутгийн төсөв, олон улсын хөгжлийн санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэлээр орон сууцны хороолол барих 8 төслийг хэрэгжүүлж байна. Уг төслүүд хэрэгжсэнээр нийт 217.27 га талбайд 2027 он хүртэлх хугацаанд 28,185 айлын орон сууцны цогцолбор хороолол баригдаж, 100,000 орчим иргэн тав тухтай инженерийн дэд бүтцэд холбогдсон, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. | |
| 19 | | 3.2.8. Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчныг бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ. | 2020 - 2050 | - | Зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | -Сургуулийн спорт заал /540 м2/, Сургуулийн спорт заал 720м2 зураг төсөл гүйцэтгэх ажлыг 2021 онд дуусган БШУЯ-нд хүлээлгэн өгсөн. -Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар баригдах "President" спорт цогцолборын барилгыг Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт төлөвлөж байгаа бөгөөд шаардлагатай зургийн даалгаврыгТөрийн нарийн бичгийн даргын , зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд "Говь трэйвэл" ХХК-тай гэрээ байгуулж эскиз зургийг зөвшилцөж байна. | 70% |
| 20 | | 3.2.9. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно. | 2020 - 2050 | - | Зээлийн батлан даалтын сангийн журмыг шинэчилнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.2 дахь заалтыг "Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн" гэснийг "Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээл, орон нутгийн хөдөлмөр эрхлэгчдэд олгогдож байгаа ипотекийн зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн" гэж өөрчлөх санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, төсөлд тусгуулсан. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн БХБСайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 09 дүгээр тушаалаар ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилаа төлбөрт батлан даалт гаргах өөрчлөлтийн саналыг боловсруулж зээлийн батлан даалтын сангийн журмын төсөлд тусгуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. Журмын төслийг Шадар сайдын 2022 оны 39 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулсан. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл батлагдсанаар дээрхи журам дагаж батлагдахаар хүлээгдэж байна.Хөдөө, орон нутагт төлбөрийн чадварт нийцсэн орон сууц худалдан авах эрх зүйн орчны бүрдүүлэх зорилгоор Шадар сайдаар ахлуулсан Сангийн яам, Монголбанкны төлөөлөл орсон дэд ажлын хэсэг байгуулагдан, холбогдох мэдээллийг цуглуулж, эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголд хөдөө, орон нутагт анх удаа орон сууц худалдан авах иргэний ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд 8.0 тэрбум төгрөгийг Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1651 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэн тусгаж батлуулсан. Энэ ажлын хүрээнд аймгуудад 3864 иргэн, сумуудад 773 иргэн, нийт 4637 иргэнд ипотекийн зээлийн татаасд хамрагдаж төлбөрийн чадварт нийцсэн орон сууцтай болох нөхцөл бүрдсэн. | |
| 21 | | 3.2.10. Орон сууцны зээлийн даатгалын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдийн орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ. | 2020 - 2050 | - | Зээлийн батлан даалтын сангийн журмыг шинэчилнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.2 дахь заалтыг “Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн” гэснийг “Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээл, орон нутгийн хөдөлмөр эрхлэгчдэд олгогдож байгаа ипотекийн зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн” гэж өөрчлөх санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, төсөлд тусгуулсан. Мөн БХБСайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 09 дүгээр тушаалаар ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилаа төлбөрт батлан даалт гаргах өөрчлөлтийн саналыг боловсруулж зээлийн батлан даалтын сангийн журмын төсөлд тусгуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. Журмын төслийг Шадар сайдын 2022 оны 39 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулсан. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл батлагдсанаар дээрхи журам дагаж батлагдахаар хүлээгдэж байна.Хөдөө, орон нутагт төлбөрийн чадварт нийцсэн орон сууц худалдан авах эрх зүйн орчны бүрдүүлэх зорилгоор Шадар сайдаар ахлуулсан Сангийн яам, Монголбанкны төлөөлөл орсон дэд ажлын хэсэг байгуулагдан, холбогдох мэдээллийг цуглуулж, эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн. Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголд хөдөө, орон нутагт анх удаа орон сууц худалдан авах иргэний ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд 8.0 тэрбум төгрөгийг Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1651 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэн тусгаж батлуулсан. Энэ ажлын хүрээнд аймгуудад 3864 иргэн, сумуудад 773 иргэн, нийт 4637 иргэнд ипотекийн зээлийн татаасд хамрагдаж төлбөрийн чадварт нийцсэн орон сууцтай болох нөхцөл бүрдсэн. | |
| 22 | | 3.2.11. Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй орон сууцны хэрэгцээг хангахад чиглэгдсэн хуримтлалтай дүйцүүлэх хөрөнгө оруулалт, хөнгөлөлтийн санг хослуулсан ипотекийн зээлийн уян хатан, олон хувилбарт бодлогыг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | - | Ипотекийн зээлэнд 3000 хүн хамруулна. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.2 дахь заалтыг “Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн” гэснийг “Ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих зээл, орон нутгийн хөдөлмөр эрхлэгчдэд олгогдож байгаа ипотекийн зээлийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн” гэж өөрчлөх санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, төсөлд тусгуулсан. Мөн БХБСайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 09 дүгээр тушаалаар ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилаа төлбөрт батлан даалт гаргах өөрчлөлтийн саналыг боловсруулж зээлийн батлан даалтын сангийн журмын төсөлд тусгуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. Журмын төслийг Шадар сайдын 2022 оны 39 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулсан. “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл батлагдсанаар дээрхи журам дагаж батлагдахаар хүлээгдэж байна.Хөдөө, орон нутагт төлбөрийн чадварт нийцсэн орон сууц худалдан авах эрх зүйн орчны бүрдүүлэх зорилгоор Шадар сайдаар ахлуулсан Сангийн яам, Монголбанкны төлөөлөл орсон дэд ажлын хэсэг байгуулагдан, холбогдох мэдээллийг цуглуулж, эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголд хөдөө, орон нутагт анх удаа орон сууц худалдан авах иргэний ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд 8.0 тэрбум төгрөгийг Сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1651 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэн тусгаж батлуулсан. Энэ ажлын хүрээнд аймгуудад 3864 иргэн, сумуудад 773 иргэн, нийт 4637 иргэнд ипотекийн зээлийн татаасд хамрагдаж төлбөрийн чадварт нийцсэн орон сууцтай болох нөхцөл бүрдсэн. | |
| 23 | | 3.2.12. Ногоон орон сууцыг нэвтрүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн тогтвортой тогтолцоог бүрдүүлнэ. | 2020 - 2050 | - | Журам боловсруулж батлуулна. | Барилгын салбарт ногоон шийдэл, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж гэрчилгээжүүлэх, барилгын дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн Ногоон барилгын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох үүрэг бүхий Ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021-02-01-ний өдрийн 23 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хийгдэх ажлуудыг 3 багц болгон, дэд ажлын хэсэг байгуулсан. Үүнд: Дэд ажлын хэсэг - 1: Хууль эрх зүйн орчин, Ногоон барилгын зөвлөл байгуулах замын зураглал боловсруулах, оролцогч талуудыг тодорхойлох, Дэд ажлын хэсэг - 2: Ногоон барилгын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, оролцогч талуудын хооронд уулзалт зохион байгуулах, туршлага хуваалцах, НБЗ-ийн үйл ажиллагааны журам боловсруулах, Дэд ажлын хэсэг - 3: Санхүүжилтын тогтолцоо, механизм. Барилгын дулаан хангамжийн нормыг шинэчлэн баталсантай холбогдуулан "Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам"-ын төслийг боловсруулан, холбогдох газруудаас санал авч байна. | 50% |
| 24 | | 3.2.13. Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн | 2020 - 2050 | - | Ашиглалтад орсон орон сууцны тоо 13800 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 48 байршил 42 төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022оны хагас жилийн байдлаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 11200 айлын орон сууц ашиглалтад орсон. Төслийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: 1.Сүхбаатар дүүргийн 9, 10-р хорооны Б хэсэгчилсэн талбайн 4-р ээлжийн 108 өрхийн орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлыг “Пример Инвестмент” ХХК; 2.Баянзүрх дүүргийн 13, 14-р хорооны Орон сууцны 14-р хороолол орчмын Е хэсэгчилсэн талбайн 118 өрхийн орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлыг “Зургаан талт” ХХК; 3.Баянзүрх дүүргийн 13, 14-р хорооны Орон сууцны 14-р хороолол орчмын Ё хэсэгчилсэн талбайн 135 өрхийн орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлыг “Ай Энд Жи” ХХК тус тус гүйцэтгэж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно. | | | | | |
| | | хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ. | | | ажиллагаа хангагдсан байна. | тоот албан бичгээр тус ажлын танилцуулгыг ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2022.03.09-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 15 дугаар тэмдэглэл гарсан. Засгийн газрын хуралдааны 2022 оны 15 дугаар тэмдэглэлээр “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл, “Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгасан. Үүний дагуу дагуу “Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай”, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулж, БХБ-ын сайдын 2022 оны 1/1012 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авч, тогтоолын төслүүдийг танилцуулгын хамт БХБ-ын сайдын 2022.04.19-ны өдрийн 1/1832 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2022.05.04-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2022.05.04-ний өдрийн өдрийн 180 дугаар тогтоолоор, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2022 оны 182 дугаар тогтоолоор тус тус баталсан. | |
| 50 | | 5.3.11. Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020 - 2050 | | Салбарын хэмжээний тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагааг төрийн үйлчилгээний нэгдсэн системд үе шаттайгаар холбоно. | Газар, хот байгуулалт, барилгын салбарын бүх төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох, хянан шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагаа, газрын кадастрын цахим систем, газрын кадастрын мэдээллийн лавлагаа, ундны усны чанарын нэгдсэн мэдээллийн санг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. - Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох 5 үйлчилгээ холбогдсон. - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс нийт 7 төрлийн үйлчилгээг бэлтгэн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлсэн. - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс газар эзэмших, ашиглах эрх, гэрээний лавлагаа, тодорхойлолтыг нэгдсэн нэг веб үйлчилгээ /сервис/-ээр гаргах шаардлагын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа И-Монгол академи УТҮГ-т веб үйлчилгээ /сервис/-ний шинэчлэгдсэн хөгжүүлэлтийг хийн хүргүүлсэн. Тус веб үйлчилгээ /сервис/-ээс газар эзэмших, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглах эрх, гэрээний лавлагаа, газрын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа, нэгж талбарын үнэлгээний лавлагаа, нийт 5 лавлагаа, тодорхойлолтын мэдээллийг Төрийн нэгдсэн мэдээллийн систем E-Mongolia-д гаргасан. | |
| 51 | | 5.3.18. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ. | 2020 - 2050 | | Салбарын төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангана. | Төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтуудыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчдад цахим соёлыг төлөвшүүлэх, ажлын бүтээмж, чанарыг нэмэгдүүлэх, цахим орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үүлэн технологид суурилсан Microsoft Office 365 програмын 40 хэрэглэгчийн лицензийг худалдан авч, эрхүүдийг үүсгэн, лицензийг суурилуулсан. Үүлэн технологид суурилсан Microsoft Office 365 програмаар дамжуулан албан хаагчид хаанаас ч өөрийн хадгалсан бичиг баримтуудыг нээж өөрчлөлт оруулах, өөрийн чухал файлуудаа Microsoft корпорацын One Drive үйлчилгээний файл сервер дээр найдвартайгаар хадгалах боломж бүрдүүлж, хэрэглээний талаарх сургалтыг зохион байгуулсан. Барилгын салбарын үйл ажиллагааг цахимжуулж, өгөгдлийн сан, мэдээлийн системийн хэрэглээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, өгөгдөл боловсруулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| Зургаа. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 52 | 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ. | 6.2.13. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | | Хэрэгжилтийг ханган ажиллана. | Нийслэл, Баянхонгор, Баян-Өлгий, Орхон аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дорноговь аймгийн Алтанширээ, Булган аймгийн Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байна. 2022-2025 онд хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн талбайд нөхөн сэргээлт хийх шаардлагатай 26 нэгж талбарын хэмжээ, байршлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд: Архангай аймагт 6 байршлын 930 га, Булган аймгийн 2 байршлын 269 га, Баянхонгор аймгийн 1 байршлын 294 га, Өвөрхангай аймгийн 9 байршлын 2411 га, Хэнтий аймгийн 1 байршлын 202 га, Сэлэнгэ аймгийн 2 байршлын 326 га, Төв аймгийн 5 байршлын 3589 га нийт 8021 га тариалангийн талбай байна. Тариалан болон атаршсан 26 нэгж талбарын 8021 га газарт биологийн нөхөн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргээлт хийж, олон наст ургамал тариалж, ургамлан бүрхэвч, биомассын хэмжээг нэмэгдүүлнэ. Газрын нөхөн сэргээлт хийх, доройтсон газрыг зайнаас тандан судлалын аргаар тодорхойлох үйл ажиллагаанд шинэлэг арга, аргачлалыг нэвтрүүлэх зорилгоор “Газрын мониторингийн судалгаа хийж, газрын мониторингийн аргачлал боловсруулах” үүрэгтэй зөвлөх багтай гэрээ байгуулан ажиллаж байна | |
| 53 | | 6.2.16. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй болгоно. | 2020 - 2050 | | Хэрэгжилтийг хангана. | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр дамжуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг www.egazar.gov.mn хаягаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгосон. | 100% |
| 54 | 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 6.3.1. Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна. | 2020 - 2050 | | Хэрэгжилтийг хангаж, тоолууржуулалтыг 92%-д хүргэнэ. | Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон нийт хэрэглэгчдийн 89 хувийн усны хэрэглээг тоолуурын заалтыг үндэслэн тооцож байна. Тоолууржилтын түвшин 2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт 89%, Улаанбаатар хотын хувьд 91.5%-тай буюу улсын хэмжээнд 90.7% байна. | 90% |
| 55 | | 6.3.4. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | 2020 - 2050 | | УБ хотын шинэ ТЦБ-ын цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, Дулааны 3 болон 4-р цахилгаан станцуудын техникийн усны зориулалтаар эргүүлэн ашиглах | АНУ-ын МСК-ын санхүүжилтээр Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Хаягдал усыг дахин боловсруулах төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь УБ хотын шинэ ТЦБ-ын цэвэрлэсэн усыг дахин боловсруулж, Дулааны 3 болон 4-р цахилгаан станц (ДЦС-3, 4)-уудын техникийн усны зориулалтаар эргүүлэн ашиглах зорилготой бөгөөд дараах зураг төслийн ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд: 1.ДЦС-3 ТӨХК-ийн техникийн усны зураг төслийг боловсруулсан; 2.ДЦС-4 ТӨХК-ийн техникийн усны зураг төслийг боловсруулсан; 3.Ус дамжуулах гол магистраль хоолойн трасс тогтоох; 4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ; 5.Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ; 6.Ус дамжуулах хоолойн трассын дагуу газар чөлөөлөх болон нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулсан. Ус дахин боловсруулах үйлдвэрийн барилгын талбай чөлөөлөх талаар 2022.05.13-ны 3/2386 тоот албан бичгийг УБ хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгжид хүргүүлсэн. Зураг төсөл боловсруулах ажил 60%-тай, үйлдвэрийн зураг төсөл, барилга | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлыг үргэлжлүүлнэ. | угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт шалгарсан “М-Си-Эс Проперти” ХХК, туслан гүйцэтгэгч Францын “Egis Water and Maritime” болон “Veolia Water Technologies” компанитай 2022.05.10-нд гэрээ байгуулсан. | |
| 56 | | 6.3.14. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөн, шинээр барьж, шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ. | 2020 - 2050 | | Үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1.АНУ-ын МСК-ын санхүүжилтээр Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих төсөл хэрэгжиж байна. Энэхүү төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн хоёр шинэ эх үүсвэр байгуулан, олборлосон усыг олон шатлалаар гүн цэвэршүүлэх үйлдвэр, цэвэршүүлсэн усыг нийслэлийн ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх шугам сүлжээг барьж байгуулна. Төслийн барилга угсралтын ажлыг хоёр багцад хуваан хэрэгжүүлэх ажлын зургийг боловсруулж батлуулсан.Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Газрын доорх усны ашиглалтын цооног өрөмдөх, тоноглох, ус дамжуулах хоолойн барилга угсралтын ажлын тендерт шалгарсан Израил улсын Baran групптэй 2022.05.26-нд гэрээ байгуулсан. УБ хотын УСУГ-т лабораторын тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж байна. Мөн УБ хотын төвлөрсөн сүлжээнд холбогдсон 180 орчим ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах тендерийг зарлаж, 2022.06.20-нд нээсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Улсын төсвийн 40.0 сая төгрөг, гадаад тусламжийн 28,409.02 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон. Төслийн хэрэгжилт 10%. 2. 19 аймгийн 59 сумын төвд "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2021 оны 161 дугаар тогтоолоор батлуулсан. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд 59 сумын төвийн төвлөрсөн ус хангамжийн системийг шинээр барьж байгуулах ба стандартын шаардлага хангасан унд ахуйн усаар сумын төвийн ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг хангахаар төлөвлөж байна. Дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд 2022 онд 10 аймгийн 18 суманд дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээ түүний барилга байгууламжийг барих ажлыг эхлүүлүүлээд байна. | 30% |
| 57 | 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн | 6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) | 2020 - 2050 | | Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний | Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг 2021-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн биелэлтийг гарган БОАЖЯ-нд 2022-04-22-ны өдрийн 1/1954 тоот албан бичгээр хүргүүлсэн. “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХОТ” чуулганыг БОАЖЯ болон БХБЯ, Орхон аймгийн ЗДТГ, ҮТХН-ийн Олон Улсын Түншлэл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна. | баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна. | | | хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. | НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Даян дэлхийн ногоон хөгжлийн институтээс хамтран 5 сарын 30-31-ний өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулж, БХБЯ-ны, БТГ-ын дарга “Барилга, хот байгуулалтын салбарын ҮТХН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт” сэдвээр илтгэл тавьж оролцсон. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн 2022 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд Сервер худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2022.05.12-ны өдөр хүлээн авч СМТХ-ийн шинжээчээр хүчин чадлыг шалгуулан актаар хүлээлгэн өгсөн. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, судалгааг бий болгох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүний үр дүнг хэмжих, тайлагнах, нотлох боломжийг бүрдүүлэх зорилго бүхий “Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем”-ийн мэдээллийн санг баяжуулах, сайжруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2021.05.18-ны өдрийн 114 дүгээр тушаалаар байгуулсан. Батлагдсан ажлын даалгаврын дагуу тендер зарлаж, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр “Софт мастер” ХХК шалгарч, санхүүжүүлэгч байгууллага болох ГХАОУБ-тай 2021 оны 11 сард гэрээ байгуулан, хэрэгжүүлж байна. Одоо ашиглагдаж буй системд хийсэн шинжилгээ, системийг сайжруулах шийдлийг гарган түгээгч байгууллагуудтай мэдээлэл солилцох боломж, тулгамдаж буй асуудлын талаар ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн. “Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем”-ийн мэдээллийн санг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сантай уялдуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. | |
| 58 | | 6.4.10. Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ. | 2020 - 2050 | | Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж, хамтран ажиллана. | Барилгын материалд үнэлгээ хийх ажлыг эхлүүлэх зорилгоор “Ногоон барилгын материалын тухай ойлголт” сэдэвт уулзалт, семинарыг ГОУХАН-тэй хамтран 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр “Блү Скай”-д зохион байгуулж, тус семинарт 50 гаруй хүн оролцож, “Монгол Улсад хэрэгжүүлж байгаа барилгын салбарын ногоон бодлого”, “Ногоон барилгын материалын тухай ойлголт”, тэр дундаа “Эрчим хүч шингээсэн материалын ойлголт, үнэлгээ”, “Олон улсын сайн туршлага, үнэлэх, хянах систем”-ийн талаар илтгэлүүд тавигдаж, харилцан санал солилцлоо. Энэхүү арга хэмжээний зорилго, гарах үр дүнгийн талаар МҮОНРТ, Ийгл телевиз, Малчин телевиз, Монголын радио, Ээрэг.мн сайт зэрэг мэдээллийн хэрэгслүүдэд яриа өгч, олон нийтэд мэдээлэл хүргэсэн. - Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын 1.2-д заасан “...эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ...байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлж буй аж ахуйн нэгж болох “Кинг спан” ХХК, “Голден бизнес групп” ХХК-иудыг дэмжин ажиллаж тэдгээр байгууллагад “Ногоон гэрчилгээ”, импортолж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд нь “Эко тэмдэг” олгож, дэмжлэг үзүүлж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн. - “Кинг Спан” ХХК-ийн импортлох бүтээгдэхүүнийг Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлэх тухай хүсэлтийг Сангийн сайд Б.Жавхланд 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1/2526 тоотоор хүргүүлсэн. - “Голден бизнес групп” ХХК-ийн импортлохоор зорьж буй CLT+GLTWI /cross-laminated timber/ технологийг судлан Ногоон гэрчилгээ, Эко тэмдэг олгох хүсэлтийг БОАЖЯ-нд 2022.06.21-ний өдрийн 3/3001 тоотоор хүргүүлсэн. | |
| 59 | | 6.4.21. Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. | 2020 - 2050 | | Барилгын хог хаягдлыг устгах, дахин боловсруулах журмын хэрэгжилтийг хангуулна. | “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын төслийг боловсруулж, БХБСайдын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлуулан, ХЗДХЯ-нд яамны 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/742 тоот албан бичгээр хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4731 дугаарт бүртгүүлэн мөрдөж байна. Ингэснээр барилгын хог хаягдлыг устгах, дахин боловсруулах эрхзүйн орчин бүрдсэн. - Дулааны станцуудын үнсийг цуглуулж, барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах талаар холбогдох талуудын уулзалтыг ЭХЗХ-ны байранд 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж, тус уулзалтад II, III, IY дүгээр болон Амгалангийн дулааны станцын төлөөлөл, БМҮХ ТББ, Монцемент” ХХК, Мөнхийн баян гал” ХХК зэрэг үйлдвэрлэгч нар оролцож, санал солилцсон. - ДЦС-уудын үнсийг барилгын материалд хэрэглэх талаар мэдээлэл бэлтгэн хамтран ажиллах саналыг Цөмийн энергийн комиссын ажлын албанд 2022 оны 4 дүгээр сарын 25-ны 1/1969 тоотоор хүргүүлэв. | 100% |
| 60 | | 6.4.22. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр | 2020 - 2050 | | | Гадаадын зээлээр Улаанбаатар хот болон 16 аймгийн төв, 2 сумын төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. 1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг, АХБ-ны зээлээр 10 аймгийн 12 сумын, БНФУ-ын зээлээр | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ. | | | | "Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийг, БНПУ-ын зээлээр 5 аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөлүүд 70%-тай хэрэгжилттэй байна. 2. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд 18 суманд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. 3.Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхөд хөрсөнд нэвчдэггүй нүхэн жорлон суурилуулах ажлыг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж 2022 оны хагас жилийн байдлаар он дамжин хэрэгжиж буй 3040 байгууламжаас 2738 байгууламж ашиглалтад орж, үлдсэн 302 байгууламж, 2022 онд хөрөнгө оруулалтаар батлагдсан 450 байгууламж, нийт 752 өрхийн ариун цэврийн байгууламжийг шинээр суурилуулна. | |
| 61 | | 6.4.23. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ. | 2020 - 2050 | | Лаг хатаах шатаах байгууламжийн стандартыг боловсруулна | БНХАУ-ын зээлээр УБ хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгаатай холбогдуулан лаг хатаах шатаах байгууламжийн стандартыг боловсруулах шаардлагатай болсон. Лаг хатаах шатаах байгууламжийн “Техникийн ерөнхий шаардлага” стандартын техникийн даалгаврын төслийг боловсруулсан. Ажлын даалгавар боловсруулан худалдан авах ажиллагааны тендер зарласан, Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй 2022.07.16 нд гэрээ байгуулахаар ажиллаж байна. | 30% |
| Ес. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | |
| 62 | 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай | 9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт | 2020 - 2050 | | 1100 барилгыг паспортжуулж,45 барилгыг буулган шинээр барьсан байна. | Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 127 дугаар тушаалаар баталсан. 2020 оны байдлаар Улсын хэмжээнд 2002 оноос өмнө баригдсан 7672 барилга байгууламж ашиглагдаж байгаагаас нийслэлд 1844, аймаг орон нутагт 5828 барилга байгууламж байна. Нийслэлийн 988 олон нийтийн барилга байгууламжийг паспортжуулахад 6,9 тэрбум төгрөг, аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн 2142 барилга байгууламжийг паспортжуулахад 14,9 тэрбум төгрөг тус тус шаардлагатай байгаа талаарх танилцуулгыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно. | хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна. | | | | хуралдаанд танилцуулсан. 2022 оны Нийслэлийн төсөвт 560 сая төгрөгөөр 172 барилга байгууламжийг паспортжуулах ажил туссан худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалаар Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын санхүүжүүлэх боломжтой 10 төрлийн зардалд паспортжуулах ажлын зардлыг тусган санхүүжүүлэх боломжийг оруулж баталж, үүрэгжүүлэн, хяналт тавин ажиллаж байна. - 170 барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2015-2022 онд удаа дараа зарласнаар 103 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагааны дагуу 842 айлын 48 орон сууцыг буулган, 2703 айлын 21 орон сууц ашиглалтад орсон. Үүнд: -2020 онд 183 айлын 8 орон сууцыг буулган, 360 айлын 2 орон сууц, -2021 онд 274 айлын 14 орон сууцыг буулган, 270 айлын 2 орон сууц, -2022 онд 215 айлын 2 орон сууц ашиглалтад орсон. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгаа ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилга байгууламжийг буулгаж шинээр барихад шаардлагатай санхүүжилтийг /21 тэрбум төгрөг/ 2023 оны Улсын төсөвт тусгуулахаар саналаа Сангийн яаманд хүргүүлсэн. | |
| 63 | 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө. | 9.3.1. Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг | 2020 - 2050 | | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар хэлэлцүүлж батлуулна. | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч С.Батбаясгалан нар 2020.10.01-ний өдөр баталсан. Уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлыг Нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ гүйцэтгэж байна. "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын хүрээнд уг ерөнхий төлөвлөгөөнийний концепци /үзэл баримтлал/ боловсруулж Засгийн газрын 2020.06.12-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 35 дугаар тэмдэглэл гарсан. Энэ хүрээнд Хот байгууллатын иж бүрэн үнэлгээ, Хүн ам зүйн судалгаа, Нийгмийн дэд бүтцийн судалгаа, Орон сууцны судалгаа, Эдийн засгийн судалгаа, Улаанбаатар бүсийн судалгаа, Аялал жулчлалын судалгаа, Байгаль орчны судалгаа, Гамшгийн менежментийн судалгаа, Түүх соёлын судалгаа, Хог хаягдлын судалгаа, Газар зохион байгуулалтых, Архитектур орон зайн, Зам тээврийн, Ногоон байгууламжийн, Инженерийн бэлтгэл арга хэмжээний, Дулаан хангамж, Ус хангамж, ариутгах татуургын, Цахилгаан хангамжийн, Мэдээлэл холбооны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлнэ. | | | | судалгааны ажлууд болон Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажил бүрэн хийгдэж 100 хувь дуусан, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай УИХ-ын тогтоолоор батлагдсан төслийн үзэл баримтлалынхүрээнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглийг боловсруулж ЗГ-ын гишүүдээс 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/2686 тоот албан бичиг хүргүүлэн санал авч байна. | |
| 64 | | 9.3.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 2020 - 2050 | | 25200 айл өрх орон сууцанд орсон байна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07/19, 12/43, 2014 оны 19/23, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 161, 2020 оны 48, 2021 оны 122 дугаар тогтоолуудаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийтдээ 28 байршил, 85 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 18 байршлын 56 хэсэгчилсэн талбайд 43 төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 онд 959 айлын орон сууц ашиглалтад орж өссөн дүнгээр 11755 айл өрх орон сууцанд орсон байна. Мөн энэ жилдээ 6033 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. . Дээрх 43 төсөл хэрэгжүүлэгчийн ажлын явц өнөөдрийн байдлаар: -төсөл хэвийн үргэлжилж байгаа18 төсөл хэрэгжүүлэгч, -төслийн гүйцэтгэл удааширсан 17 төсөл хэрэгжүүлэгч, -төслийн ажил дуусаж хүлээлгэн өгсөн 1 төсөл хэрэгжүүлэгч, | 30% |
| 65 | | 9.3.4. Олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 150,000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | | Хэрэгжилтийг хангана. | Төв, суурин газарт амьдардаг нийт өрхийн дийлэнх олонхын худалдан авах чадварт нийцсэн, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар 45 хувьтай, 2021 оны төлөвлөгөөний биелэлт 80 хувьтай, “хэрэгжих шатанд” байна. Ипотекийн зээлийн хөтөлбөрт 2020 онд 5594 өрх, 2021 онд 13292 өрх, 2022 оны хагас жилийн байдлаар 2886 өрх, нийт 21772 өрх 2020 оноос хойш хамрагдаад байна. Нийт ашиглалтад орсон орон сууцны хувьд 2020 оноос хойш 2020 онд 15639, 2021 онд 17478, 2022 оны хагас жилийн байдлаар 8742, нийт 41859 айлын орон сууц ашиглалтад ороод байна. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 66 | | 9.3.38. Улаанбаатар хотын “Төв цэвэрлэх байгууламж”-ийг шинэчлэн барьж ашиглалтад оруулна. | 2021 - 2030 | | Төслийн хэрэгжилт 70 хувьд хүрнэ. | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хүрээнд цэвэрлэх байгууламжийн ажлын нарийвчилсан зураг төсөл-99%, бараа материал татан авалт-30%, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт-33%, Барилга угсралтын ажил-50%-тай. Үүнд:<br>1.Өргөн сараалж, оролтын усны насосын байр, ус дамжуулах хоолойг зөөн шилжүүлэх ажил 90%;<br>2.Биореактор 1-ийн сангийн хана, хучилтын хавтангийн бетон цутгалт- 77%;<br>3.Биореактор 2-ын сангийн ханын бетон цутгалт-65%;<br>4.Гүн цэвэрлэгээний тунгаагуурын хөрсний ус шавхах, газар шорооны ажил-100%;<br>5. 35кВ-ын дэд станцын газар шорооны ажил 10%; | 50% |
| 67 | 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ. | 9.5.2. “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | | Инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлнэ. | УИХ-ын 2022 оны 10-р тогтоол, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт “Хөшигийн хөндийн ЭЗЧБ” байгуулах тухай, Засгийн газрын 2022 оны 143-р тогтоол “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай”, 2022 оны 98-р тогтоолыг “Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолуудыг тус тус батлуулсан. Засгийн газрын 2022 оны 143-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажлыг “Некст степ инженеринг” ХХК /200.0 сая төг/, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /234.0 сая төг/, “Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” /339.6 сая төг/-ний ажлыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ, “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг /700.0сая төг/ “Нарт дизайн” ХХК, ИНЕГ-ын 600 айлын орон сууцны барилгын ажлын зураг төслийн ажлыг /300.0 сая төг/ “Кон-Консалтинг” ХХК боловсруулж, нийт 1,773.6 сая.төг-ийн ажил хийгдэж байна. Мөн Төрийн захиргааны байгууллагуудын ажиллах нэгдсэн байрны ажлын зураг төсөл боловсруулах /1.2 тэрбум төг/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг боловсруулж байна.<br>“Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтэц” төслийн хүрээнд “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 2,173.3 сая төгрөгийн 6ш ажлын зураг төслийн явц 86,7%-тай, БУА-ын 33,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын тендер зарлагдсан. АХБ-ны 2021-2024 онуудад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегид багтсан зээл, буцалтгүй тусламж, техникийн туслалцааны хүрээнд “Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтцийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх саналыг тус банканд хүргүүлээд байна. | |
| 68 | 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ. | 9.5.3. Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. | 2020 - 2050 | | Инженерийн дэд бүтцийн буюу дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний нарийвчилсан зураг төслийг боловсруулна. | “Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төв байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байр зүйн зураг боловсруулах” ажлыг нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ 2021/45 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 1/1023 тоот албан бичгээр гэрээт ажлын эхлэлийн шатны тайланг дүгнэсэн актыг БХТ-өөс ирүүлсэн. “Олон улсын нисэх онгоцны “Чингис хаан” буудлыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил”-ын ажлын даалгаварт холбогдох өөрчлөлтийг оруулан дахин боловсруулж Барилга, хот байгуулалтын сайдаар 2021.10.20-ний өдрийн 2021/81 тоот ажлын даалгаврыг батлуулсан. Барилгын хөгжлийн төвөөс 2021.12.10-ний өдрийн 1/3549 тоот албан бичгээр дунд шатны тайланг баталгаажуулан ирүүлсэнийг хянан үзэж гэрээний дагуу санхүүжилтийг олгосон. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа 2022.04.17-нд дуусгавар болж, алданги тооцогдож байгаа бөгөөд ажлын явц 80 % байна. -Уг ажлыг ЗГ-ын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж байна. "Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төсөл, арга хэмжээний хүрээнд  дараах тендерийг зарлаад байна. Үүнд: 1. XII.1.89.1 “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил - Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2*10000кВА чадалтай “Хөндий” дэд станц, 110/35/10кВ-ын “Зуунмод” дэд станцын өргөтгөл /Төв/ Төсөв өртөг 12500.0 сая төгрөг;  2. XII.1.89.2 “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний ажил-Үерийн хамгаалалтын суваг-4 /Төв/ 8700.0 сая төгрөг;  3. XII.1.89.3 “Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний ажил - /Төв/ 11800.0 сая төгрөг./ | 100% |